



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын  
Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн сул орон тоонд  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /77/ авсан Төмөрхуягийн Эрдэнэцэцэгийг Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Т.Эрдэнэцэцэгийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг сумын Засаг дарга /Д.Баянмөнх/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Баян-Овоо сумын Засаг даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР